



АУДИТЫН НЭР: “2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Тайлангбэлтгэсэн:

ААГ-ын Санхүүгийн аудитын баг

Газрын дарга, тэргүүлэх
аудитор

Ч.Чүлтэмбат

Аудитын менежер

Ш.Мөнхбаяр

Аудитор

Ч.Гантулга
С.Санжаажав

2018 оны 10 дугаар сар

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал 7037-
3089, 7037-8142 дугаарын
утсаар харилцана уу.

ХАЯГ:

Аймгийн аудитын газар
Аймгийн ЗДТГ-ын байр
Дархан-Уул аймаг

Товчилсон үгийн жагсаалт 3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй . . . 4-5

Бүлэг 1

- 1.1. Аймгийн нэгдсэн хүрээний төсөв, төсвийн хүрээний мэдэгдэл шалгууртай нийцжээ...6
- 1.2. ХБГ-ээр төсвийн орлого 98.9 хувьтай биелэхээр байна.....7
- 1.3. ХБГ-ээр төсвийн зарлага 94.6 хувьтай биелэхээр байна.....8
- 1.4. Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр үндэслэлтэй байна.....9

Бүлэг 2

- 2.1. Орлогын төлөвлөгөө хэрэгжих боломжтой байна..... 10
- 2.2. Улсын төсөөс орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэг аваагүй..... 11
- 2.3. Орлогыг нэмэгдүүлэх боломж байна..... 12

Бүлэг 3

- 3.1 Нийт зарлагын төлөвлөгөө ХБГ-ээр 96.3 хувиар биелэхээр байна..... 13
- 3.2 7 төсөл арга хэмжэний эрх шилжиж иржээ..... 14
- 3.3 Тендер шалгаруулах явцад 7 гомдол санал гарчээ..... 15
- 3.4 Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаастай асуудал байхгүй..... 15

Бүлэг 4

- 4.1 Хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ..... 16
- 4.2 Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ТАХ-ний явцын шалгалтыг 2 удаа хийсэн байна..... 16

Дүгнэлт, зөвлөмж.....17

Товчилсон үгийн жагсаалт

АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
ХБГ	Хүлээгдэж байгаа гүйцэтгэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ИШС	Инженерийн шугам сүлжээ
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/125 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний 38 дахь заалтыг үндэслэн гүйцэтгэнэ.

Аудитын зорилт:

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль болон түүний хэрэгжилтийн явцыг шалгаж, дүгнэлт гарган таницуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Дархан-Уул аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх,
- Дархан-Уул аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх,
- Дархан-Уул аймгийн 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх,
- ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх,

Аудитын хамрах хүрээ:

Аудитыг Дархан-Уул аймгийн ТЕЗ-дын эрхлэх асуудлын хүрээний Орон нутгийн ТЕЗ-дын 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэнэ.

Үндсэн мэдээлэл:

Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 9/06 тоот тогтоолоор, 2018 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлогын хэмжээг 55,100.4 сая, зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 54,817.6 сая төгрөг байхаар баталсан байна.

Дархан-Уул аймгийн 2018 оны төсвөөс Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 458.9 сая төгрөгөөр баталжээ.

Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, урьдчилсан дүн шинжилгээ, судалгаанд үндэслэн ерөнхий эрсдэлийг “ДУНД” гэж үнэлсэн. /Хавсралт №01-д үзүүлэв/

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын Дээд байгууллагуудын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын болон Гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл

цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулна. (Аудитын асуудлын шинжилгээ, арга зүйг хавсралт № 1,2-оос үзэх)

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Бусад холбогдох хууль, тогтоомж, журам, зааврууд

Бүлэг 1

Төсвийн орлогыг 4.9 тэрбум, зарлагыг 5.3 тэрбум төгрөгөөр нэмж баталсан байна.

НЭГ. АУДИТЫН ДҮН**1.1 Аймгийн нэгдсэн төсөв, төсвийн хүрээний мэдэгдэл, шалгууртай нийцжээ.**

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн хуралдаанаар баталсан Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар Дархан-Уул аймгийн орон нутгийн суурь орлогыг 19,531.3 сая, суурь зарлагыг 18,766.4 сая, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих суурь зарлагыг 737.6 сая, аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 2,933.2 сая, тусгай зориулалтын шилжүүлгийг 33,902.8 сая, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 458.9 сая, ТЗШ-ийн байгууллагуудын өөрийн орлого 169.7 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Аймгийн орон нутгийн төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай, Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиудийн холбогдох заалт, тусгай шаардлагууд, зарчмууд болон Засгийн газрын “Орон нутгийн төсвийн аргачлал” батлах тухай 2012 оны 30, Төсвийн үр ашгийг сайжруулах, хэмнэлтийн горимд шилжүүлэхтэй холбоотой УИХ-ын 2014 оны 70, 2015 оны 108, 2016 оны 47, 2017 оны 29 дүгээр тогтоолууд, Засгийн газрын 2014 оны 147, 2015 оны 184 тогтоолууд, Сангийн сайдын “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” батлах тухай 2012 оны 244, “Төсвийн зарим анхдагч ангилал батлах тухай” 2014 оны 150 дугаар тушаалууд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын гаргасан тогтоол, шийдвэр, “Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Сангийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 4-1/4116, 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4-1/6541 тоотоор ирүүлсэн 2018 оны орон нутгийн төсвийн төсөл боловсруулах чиглэлийг тус тус удирдлага болгон боловсруулж, аймаг, сумдын ИТХ-аар баталсан байна.

/сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	УИХ-аас баталсан төсөв	Аймаг, сумдын ИТХ-аар баталсан төсөв	Зөрүү
Төсвийн орлого	19,531.3	24,482.0	4,950.7
Төсвийн зарлага	18,766.4	24,023.0	5,256.6
Орлогын шилжүүлэг /ОНХС/	2,933.2	2,933.2	-
Тусгай зориулалтын шилжүүлэг	33,891.1	33,902.8	11.7
Төвлөрүүлэх орлого	458.9	458.9	-
Гадаадын төслийн зээл	4,200.0	4,200.0	-

ТЗШ-ийн байгууллагуудын өөрийн орлого	169.7	169.7	-
---------------------------------------	-------	-------	---

Эдийн засгийн төлөв байдалд тулгуурлан 2018 оны төсвийн орлогын төлөвлөгөөг төсвийн тэнцвэртэй байдлыг баримтлах, орон нутгийн хэмжээнд татвар төлбөр хураамжийн тогтвортой орчинг хангах, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах зарчмыг баримтлан төсвийн орлогыг 4,950.7 сая, зарлагыг 5,256.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ.

1.2 ХБГ-ээр төсвийн орлого 98.9 хувьтай биелэхээр байна.

Аймаг, сумдын ИТХ нь 2018 онд орон нутгийн төсөвт 1 удаа тодотгол хийж, 2018 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвөөс нийт орлогыг 2,422.5 сая төгрөгөөр өсгөж, 68,014.6 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн нийт орлогын ХБГ-ийг хүснэгтээр үзүүлбэл:

Үзүүлэлт	2018 он										
	Өмнөх оны гүйцэтгэл	Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	ХБГ				нийт	зөрүү	хувь
				09.30	10	11	12				
Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	68,197.5	65,592.1	68,014.6	51,230.2	5,132.9	5,411.8	5,461.6	67,236.5	(778.1)	98.9	
НИЙТ ОРЛОГО	22,202.7	23,839.9	24,085.9	17,815.8	1,781.7	2,094.8	1,935.0	23,627.3	(458.6)	98	
УРСГАЛ ОРЛОГО	22,202.7	23,839.9	24,085.9	17,815.8	1,781.7	2,094.8	1,935.0	23,627.3	(458.6)	98	
Татварын орлого	20,064.7	21,857.4	21,904.8	15,944.8	1,623.6	1,867.0	1,721.6	21,157.0	(747.8)	96.6	
Татварын бус орлого	2,138.0	1,982.5	2,181.1	1,871.0	158.1	227.8	213.4	2,470.3	289.2	113.3	
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	43,153.7	41,752.2	43,928.7	33,414.4	3,351.2	3,317.0	3,526.6	44,131.8	203.1	100.5	
ОН-ийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	1,773.3	2,933.2	2,933.2	2,225.6	206.6	168.1	332.8	2,933.1	0	100	
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	33,967.9	32,337.3	33,902.8	24,491.1	3,127.5	3,131.8	3,152.4	33,902.8	0	100	
ТЗШ-ээр санхүүжих байгууллагын өөрийн орлого	232.4	169.7	279.8	208.2	17.1	17.1	41.4	283.8	4.0	101.4	
Бусад тусламж	464.0										
Гадаадын төслийн зээлээс	6,716.1	4,200.0	4,200.0	4,399.2				4,399.2	199.2	104.7	
ОНЫ ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	2,841.1	2,112.0	2,612.9	2,090.3				2,612.9	0	100	

Нийт орлогын гүйцэтгэл 2018 оны ХБГ-ээр 67,236.5 сая төгрөгт хүрч, анх батлагдсан төсвөөс 2.5 хувь буюу 1,644.4 сая төгрөгөөр илүү, тодотгосон төсвөөс 1.1 хувь буюу 778.1 сая төгрөгөөр дутуу биелэхээр байна. Энэ нь татварын орлогын төвлөрүүлэлт 2 хувиар дутуу байна.

Тусламжийн орлогын гадаадын төслийн зээл 104.7 хувь буюу 199.2 сая төгрөгөөр илүү байгаа нь “Дархан хотын бохир усны менежмент МОН3245” төслийн санхүүжилтийн ханшийн зөрүү, ТЗШ-ээр санхүүжих байгууллагын өөрийн орлого дээр ХБГ-ийг нэмснээр илүү гарчээ.

Орон нутгийн төсвийн орлогыг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас хуулиар олгогдсон зарим татварын хувь хэмжээг өсгөж тогтоосон тогтоол болон төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг үндэслэн, цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварыг 970.0 сая, газрын төлбөрийг 50.0 сая, газрын дуудлага худалдааны орлогыг 300.0 сая, ХХОАТ-ын буцаан олголтын зөрүүг 13.4 сая, түгээмэл тархацтай АМАТ-ийг 12.4 сая, ойн нөөц ашигласны төлбөрийг 8.7 сая, нэр заагдаагүй бусад орлогыг 15.0 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 20.1 сая төгрөгөөр тус тус бууруулж, АТӨЯХАТ-ыг 70.0 сая, ус рашаан ашигласны төлбөрийг 269.3 сая, хүү, торгуулийн орлогыг 200.0 сая, хадгаламжийн хүүгийн орлого 770.3 сая, хөрөнгө борлуулсны ОАТ-ыг 3.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр төсөвт зохицуулалт хийн баталсан байна.

1.3 ХБГ-ээр төсвийн зарлага 94.3 хувьтай биелэхээр байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны төсвийн нийт зарлага 68,014.6 сая төгрөгөөр батлагдсанаас ХБГ-ээр 64,107.1 сая төгрөг зарцуулж, зардлын гүйцэтгэл 94.3 хувьтай гарахаар байна. Үүнээс тусгай зориулалтын шилжүүлгийн зарлага 33,902.8 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс ХБГ-ээр 33,902.8 сая төгрөг буюу 100 хувийн, орон нутгийн төсвийн нийт зарлага 26,511.3 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс ХБГ-ээр 24,051.0 сая төгрөг буюу 90.7 хувийн гүйцэтгэлтэй харагдаж байна.

Тайлант оны нийт зарлагыг ХБГ-ийг батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулбал:

Үзүүлэлт	2018 он					
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ХБГ	Нийт	Зөрүү	Хувь
		09.30	10, 11, 12 сар			
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	68,014.6	48,084.5	16,022.6	64,107.1	(3,907.5)	94.3
Урсгал зардал	54,275.4	39,120.0	14,511.6	53,631.6	(643.8)	98.8
БАҮ-ний зардал	39,355.2	27,046.6	10,568.9	37,615.5	(1,739.6)	95.6
Татаас	3,281.3	2,248.9	899.6	3,148.5	(132.8)	96
Урсгал шилжүүлэг	11,638.9	9,824.5	3,043.0	12,867.5	(1,228.6)	110.6
Хөрөнгийн зардал	9,539.1	4,332.3	1,511.0	5,843.3	(3,695.8)	60.3
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	4,200.0	4,632.2		4,632.2	432.2	110.3

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 264 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхээр зайлшгүй шаардлагатай зардлуудыг тооцон төсөвт зохицуулалт хийж, Халамжийн санг 270.3 сая төгрөгөөр бууруулж дараах орон нутгийн байгууллагуудын зайлшгүй зардлыг санхүүжүүлэх болсон байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын төсвийг 8.0 сая, Орон нутгийн нөөц хөрөнгийг 10.0 сая, АЗДТГ-ын төсвийг 14.3 сая, аймгийн Захирагчийн албаны төсвийг 2.0 сая, НААҮГ-ын төсвийг 44.4 сая, ОНӨГ-ын төсвийг 3.2 сая, СХААлбаны төсвийг 4.6 сая, Хонгор сумын ИТХ-ын төсвийг 2.5 сая, Хонгор сумын ЗДТГ-ын төсвийг 18.9 сая, Дархан сумын ЗДТГ-ын төсвийг 36.3 сая, Орхон сумын ЗДТГ-ын төсвийг 0.9 сая, Орхон сумын ИТХ-ын төсвийг 0.7 сая, ОНХөрөнгө оруулалтыг 124.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталжээ.

1.4 Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр үндэслэлтэй гарчээ.

Тайлант онд орон нутгийн төсвийн зарлага 68,014.6 сая төгрөгийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэхдээ урсгал орлогоос 24,085.9 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс 33,902.8 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгээс 2,933.2 сая, гадаадын төслийн зээлээс 4,200.0 сая, оны эхний үлдэгдлээс 2,612.9 сая, нийт 68,014.6 сая төгрөг байхаар төсөвлөжээ.

БҮЛЭГ 2

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газрын орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

2.1 Орлогын төлөвлөгөө бүрэн хэрэгжих боломжтой байна.

Аймгийн 2018 оны 9 сарын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 92.2 хувьтай байгаа бол аймаг, сумдын тодотгосон төсвөөр 2018 оны нийт орлогын төлөвлөгөөг 68,014.6 сая төгрөгөөр баталж, оны эцэст хүлээгдэж байгаа орлого 67,236.5 сая буюу 98.9 хувьтай биелэхээр байна.

2.2 Дархан-Уул аймаг Монгол Улсын 2018 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг аваагүй байна.

2.3 Орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

Сангийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 4-1/4116, 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4-1/6541 тоотоор ирүүлсэн 2018 оны орон нутгийн төсвийн төсөл боловсруулах чиглэлийг удирдлага болгон орлогын төлөвлөгөөг боловсруулж, аймаг, сумдын ИТХ-аар баталжээ.

Аймгийн орон нутгийн төсвийн байгууллагууд өнгөрсөн оны орлогод суурилан орлогын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан ч орлогын төлөвлөлтийг эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийн таамаглалтай уялдуулах, тооцоо судалгаагүй, бодитой бус орлого төлөвлөх асуудал гарч байна. Үүнд:

- “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГазар замын сангийн орлогын төлөвлөгөөг өнгөрсөн оны орлогод суурилж төлөвлөсөн.

Замын сангийн хураамжийн орлогын харьцуулалт:

Орлогын төрөл	Орлогоор тооцсон		Аудитаар			Зөрүү
			Автотээврийн хяналтын үзлэгт орсон тээврийн хэрэгслийн тоогоор тооцсон			
	Төлөвлөгөө жилээр	Гүйцэтгэл	Тээврийн хэрэгслийн тоо	Хураамж	Нийт	
2017 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар						
Замын сан	94,500.0	96,177.0	14,393	15.0	216,000.0	121,500.0
2018 оны 08 дугаар сарын 31-ны байдлаар						
Замын сан	110,000.0	74,748.0	12,254	15.0	183,810.0	73,810.0
Нийт						195,310.0

Дээрх хүснэгтээс үзэхэд авто тээврийн хяналтын үзлэгт орсон тээврийн хэрэгслээр төлөвлөлтийг тооцоогүйгээс 195.3 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж чадаагүй байна.

Замын цагдаагийн албатай хамтран автотээврийн хяналтын үзлэгт хамрагдсан 256 тээврийн хэрэгслийг шалгахад замын сангийн хураамж төлсөн 58 жолооч байгаа нь орлого бүрдүүлэлт хангалтгүй байгааг харуулж байна. Шалган бүртгэх товчооны хураамжийн орлогын төвлөрүүлэлт дээр хяналт хийхэд хураамжийн ажилтан оройн 23 цагаас хойш ажилладаггүй тохиолдол гарч байсан.

Иймд дээрх байдлуудыг засах талаар ажил зохион байгуулахыг “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-т албан шаардлага хүргүүлсэн.

- Аймагт байршуулсан албан байгууллагуудын реклам самбарын орлого төвлөрүүлэлтийн 2018 оны төлөвлөгөө 69.1 сая төгрөг, 9 дүгээр сарын 30-ны байдлаар гүйцэтгэл 10.0 сая төгрөг байгаа нь графикт хугацаандаа орлого орж ирэхгүй байна. Үлдсэн орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар аймгийн Захирагчийн албанд албан шаардлага хүргүүлээ.

- Татварын орлого бүрдүүлэлт 2018 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 102.7 хувийн биелэлттэй гарсан боловч зарим нэр төрлийн татварын төлөвлөгөө, гүйцэтгэл ихээхэн зөрүүтэй гарчээ.

Татварын орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү

№	Орлогын нэр төрөл	2018 оны 09 дүгээр сарын 30		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Хадгаламжийн хүүгийн орлого	854.5	1,558.4	703.9	186
2	Бууны албан татвар	21.7	6.9	(14.8)	32
3	Газрын төлбөр	568.7	494.8	(73.9)	87
4	Газрын дуудлага худалдааны орлого	100.0	16.5	(83.5)	17
5	Ус рашаан ашигласны төлбөр	501.6	667.2	165.6	133
6	Байгалийн ургамал ашигласны ашигласны төлбөр	1,100.0	644.6	(455.2)	59
7	Бусад татвар	524.6	968.8	444.2	185
8	Төсөвт байгууллагын өөрийн орлого	174.8	85.0	(89.7)	49

Дээрх хүснэгтээс үзэхэд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үйлдвэр үйлчилгээний зориулалттай газрыг Засаг даргын 2018 оны 01-А/18, А/194, А/208, А/282 дугаар захирамжаар газрын дуудлага худалдаа зохион байгуулсан боловч оролцогч ирээгүйгээс газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөө, цаг агаарын байдлаас шалтгаалан хадлан авах хугацаа хойшлогдож байгалийн ургамал ашигласны орлогын төлөвлөгөө тус тус биелээгүй бол үлдсэн татварын орлогын биелэлт ихээхэн хэлбэлзэлтэй гарсан байна.

Энэ нь тогтсон судалгаа шинжилгээнд суурилж орлогын төлөвлөгөөг боловсруулах шаардлагатайг харуулж байна. Тухайлбал: Төрийн сангийн орлогын

мэргэжилтэн орлого төлөвлөх тал дээр хийсэн судалгаа шинжилгээ байхгүй, орлогын мэргэжилтэн ойр ойрхон солигдсонтой холбоотой гэж дүгнэхээр байна.

БҮЛЭГ 3**Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байна.****3.1 ХБГ-ээр зардлын биелэлт 94,3 хувьтай биелэхээр байна.**

Аймгийн 2018 оны III улирлын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр зардлын гүйцэтгэл 89.3 хувьтай байгаа бол Аймаг, сумдын тодотгосон төсвөөр 2018 оны нийт зардлын төлөвлөгөөг 68,014.6 сая төгрөгөөр баталж, оны эцэст хүлээгдэж байгаа зардал 64,107.1 сая буюу 94.3 хувьтай биелэхээр байна.

3.2 Эрх шилжиж ирсэн 7 төсөл арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Дархан-Уул аймагт 2018 онд нийт 10,714.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр аймгийн Засаг даргад эрх шилжүүлснээс гүйцэтгэгч байгууллагуудтай 9,819.8 сая төгрөгийн гэрээ байгуулж, батлагдсан төсвийг 895.0 сая төгрөгөөр хэмнэжээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын гүйцэтгэлийг төсөл арга хэмжээ бүрээр задалбал:

- Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Дархан сум 7,8 дугаар баг/-ний ажлыг 4,203.5 сая төгрөгөөр барих гэрээ байгуулж, батлагдсан төсвийг 530.8 сая төгрөгөөр,
- Багийн төвийн барилга /11,12,13,14,15 дугаар баг/-ыг 1,367.9 сая төгрөгөөр барих гэрээ байгуулж, батлагдсан төсвийг 32.1 сая төгрөгөөр,
- Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын засвар /10-16 дугаар баг/-ын ажлыг 490.5 сая төгрөгөөр засах гэрээ байгуулж, батлагдсан төсвийг 9.5 сая төгрөгөөр,
- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын засварын ажлыг 28.4 сая төгрөгөөр засах гэрээ байгуулж, батлагдсан төсвийг 2.1 сая төгрөгөөр,
- Цэцэрлэгийн барилга худалдан авахад 900.0 сая төгрөгөөр худалдан авах гэрээ байгуулж, батлагдсан төсвийг 0 төгрөгөөр,
- Төрөх эмнэлгийн барилгын өргөтгөлийг барих ажлыг 2,681.1 сая төгрөгөөр барих гэрээ байгуулж, батлагдсан төсвийг 318.9 сая төгрөгөөр
- ХХҮГ-ын Төмөр замын павилоны тохижилт засварын ажлыг 148.5 сая төгрөгөөр засах гэрээ байгуулж, 1.5 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Дээрх төсөл арга хэмжээнүүдийн хувьд аймгийн Засаг дарга худалдан авах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулснаас гүйцэтгэгч компанитай байгуулсан

гэрээт 3 ажил хугацаандаа бүрэн хийгдэж, үлдсэн ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байна.

3.3 Тендерийн явцад 7 санал гомдол гарчээ.

Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаагаар 2018 онд нийт 10,714.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр, 6,988.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгөөр, 1,434.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тус тус санхүүжүүлэхээр сонгон шалгаруулалтыг явуулжээ.

Сонгон шалгаруулалтын явцад 7 төсөл арга хэмжээнд оролцсон аж ахуйн нэгжээс Сангийн яамны Хууль эрх зүйн газар болон Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт гомдол гаргасныг шийдвэрлэсэн байна. Үүнд:

- ОНТХ-өөр хийгдэх 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дархан-Уул аймгийн урт хугацааны бодлого боловсруулах зөвлөх үйлчилгээ ДА-ОНӨГ/2017-128” төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтанд оролцсон “Ди Ди Эж” ХХК,
- ОНХСХ-өөр хийгдэх 148.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дархан сумын 1,2,3, Малчин багуудын гэр хороолол доторх хайрган хучилттай 2.77 км авто замын ажил”-ын сонгон шалгаруулалтанд оролцсон “Дархан АЗЗА” ТӨХК,
- УТХ-өөр хийгдэх 4,734.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дархан сумын 7,8 дугаар багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажил БХБЯ/1802047”-ын сонгон шалгаруулалтанд оролцсон “Одкон холдинг” ХХКомпаниудын Сангийн яам, Хууль эрх зүйн газарт гаргасан гомдолд “Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй” гэсэн шийдвэрийг тус тус өгчээ.
- УТХ-өөр хийгдэх 3,000,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төрөх эмнэлгийн барилгын өргөтгөл” төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтанд оролцсон “ЗМК глобаль” ХХК,
- ОНТХ-өөр хийгдэх 633.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дархан сумын 6,7,8-р багийн нутаг дэвсгэр дэхь төв авто замыг хатуу хучилттай болгох 2 үе шатны ажил”-ын сонгон шалгаруулалтанд оролцсон “Дархан АЗЗА” ТӨХК-уудын Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт гаргасан гомдлыг “Гомдол үндэслэлгүй” гэсэн шийдвэрийг тус тус өгсөн байна.

Сангийн яамны Хууль эрх зүйн газар 55.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Салхит багт авто зогсоол хийх ажил”-ын сонгон шалгаруулалтанд оролцсон “Ганзосон констракшн” ХХК-ийн гаргасан гомдлыг үндэслэлтэй гэж үзэн “Үнэлгээг дахин хийх” гэсэн шийдвэрийг өгсөн бол 3,106.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дархан сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт 60 айлын орон сууцны барилга,

угсралтын ажил”-ын сонгон шалгаруулалтанд оролцсон “ТИ ӨҮ БИ” ХХК-ийн гаргасан гомдлыг үндэслэлтэй гэж үзэн “Тендер шалгаруулалтыг хүчингүй болгох” шийдвэрийг өгчээ. Үнэлгээний хороо тендерийг нийтэд нь хүчингүй болгож дахин зарласан боловч Үнэлгээний хорооны шаардлага хангасан оролцогч ирээгүй тул хүчингүй болгож Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3-т заасны дагуу захиалагчид гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхийг санал болгожээ.

ХОХБТХ-с аймгийн Орон нутгийн өмчийн албанд 2018 онд санхүүжигдсэн ТАХ-г хөрөнгөнд бүртгэх дүнг нэгтгэж ашиглагч байгууллагуудын тайлан бүртгэлд бүртгэх ажилд хяналт тавин ажиллаж байна.

3.4 Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаастай холбоотой асуудал байхгүй.

БҮЛЭГ 4**Хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.**

ТАХ-ний хэрэгжилтэнд аймгийн ИТХ-ын даргаар ахлуулсан хяналт тавигджээ.

4.1 Дархан-Уул аймагт 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13 төсөл арга хэмжээг 17,695.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 67 төсөл арга хэмжээг 11,449.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгэлийн ажил явагдаж байна.

Аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсээс эхний хагас жилийн ажлын явцад хийсэн үнэлгээгээр ерөнхий дундаж 89.7 хувь буюу 4.5 онооны үзүүлэлттэй гарсан байна.

4.2 Аймгийн ИТХ-ын дарга Г.Эрдэнэбатаар ахлуулсан ажлын хэсэг байгуулан Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлын явцын шалгалтыг 2 удаа хийжээ.

Аймгийн ИТХ-ын дарга Г.Эрдэнэбат уг ажилтай танилцах үеэрээ төр хувийн хэвшлийн хооронд байгуулсан гэрээний гүйцэтгэлийг бүрэн хангах, хугацаа хожимдож байгаа зөрчлийг даруй арилгах тухай мэргэжлийн байгууллагуудын шаардлагыг хангах, хүний нөөцийг нэмэгдүүлэх үүрэг чиглэлийг зарим компанийн удирдлагуудад өгсөн байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ХОЁР: ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг өгч байна.

1. Аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогын төлөвлөгөө ХБГ-ээр 98.9 хувьтай гарахаар байна.
2. Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэл ХБГ-ээр 3,907.5 сая төгрөгийн хэмнэлттэй гарахаар байна.
3. Төсөвт тодотгол хийсэн нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалттай нийцээгүй байна.

ГУРАВ: ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагч С.Насанбат, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Б.Жаргалсайхан нарт зөвлөх нь:

- Татварын орлогын зарим төрлийн төлөвлөгөө, гүйцэтгэл ихээхэн хэлбэлзэлтэй гарч байгаа тул тогтсон тооцоо судалгааны үндсэн дээр төлөвлөгөөг боловсруулах
- Орон нутгийн замын сан болон шалган бүртгэх товчооны хураамжийн орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа бодит үзүүлэлттэй уялдуулж байх

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагыг биелүүлэх, зөрчлийг давтан гаргаагүй байх талаар арга хэмжээ авч, зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 12 дугаар сарын 22-ны дотор ирүүлэх.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР